

МОНГОЛ УЛС. ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОЛОЛЦОО, ХЭТИЙН ТӨЛӨВ

А. Буянтагс

Монгол оронд ардчилал хөгжиж, олон намын тогтолцоо бүрэлдэж, төрийн шинэ парламентын систем тогтсон хөгжлийн харнуцлагатай өнөө үед манай засгийн газраас өөрчлөн байгуулалтыг улам гүнзгийрүүлж, ойрын ирээдүйд нийгэм-эдийн засгийн хөгжлийн хурдцыг түргэтгэх, зах зээлийн эдийн засагт шилжих, нийгмийн оюуны чадавхи, нийгэм-байгалийн баялгийг хамгийн үр өгөөжтэй ашиглах, эдийн засгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх, ард түмнийхээ аж амьдралын төвшинг тууштай дээшлүүлэх, хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах эдийн засгийн чухал зорилтуудыг дэвшүүлэн тавилаа.

Манай Засгийн газраас улс орны нийгэм-эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар ойрын хугацаанд баримтлах чиг бодлогыг боловсруулсан. Энэхүү чиг бодлогод тусгагдсан арга хэмжээ нь 1995 оныг дуустал хугацааг хамарч байгаа бөгөөд тэдгээрийг жил бүрийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөгөөр тодотгон хэрэгжүүлнэ.

Засгийн газар гадаад улс оронтой хамтран ажиллах, олон улсын хөдөлмөрийн хуваарь, дэлхийн бүс нутгийн эдийн засаг, зах зээлийн харилцаанд оролцохдоо эрх тэгш харилцан ашигтай байх зарчмыг баримталж, юуны өмнө Орос, Хятад улстай хамтын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулан, үр ашигтай хөгжүүлэх зорилт тавьж байгаа юм. Үүний зэрэгцээ олон улсын байгууллага, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын фонд, Дэлхийн банк, олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох бодолтой байна.

Өнөөдөр Монгол улсын өмнө эдийн засгийн талаад харилцаагаа өөрчлөн байгуулах амин чухал зорилт тулгарч байгаа юм. Эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааг хөгжүүлэхэд:

- Эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох,

- Үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийг шинэчлэн тоноглох үндсэн дээр экспортын барааны нөөцийг нэмэгдүүлэх, барааны чанарыг сайжруулах,

- Эх орны түүхий эдийг боловсруулж, экспортын бэлэн бүтээгдэхүүн гаргах орчин үеийн үйлдвэрүүд байгуулах,

- Чөлөөт валютаар худалдах барааны фонд байгуулах /алт, мөнгө, өмнө гэдэс, ямааны ноолуур, бохир ноос, хөнгөн ба уул уурхайн үйлдвэрийн зарим бүтээгдэхүүн/.

- Үйлдвэр, гадаад худалдааны үйл ажиллагаанд маркетинг нэвтрүүлэх,

- Импортын ажиллагааг журамтай болгох,

- Улс ардын аж ахуйн салбаруудыг машин тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслээр хангах асуудлыг бооцон худалдаагаар хангах шинэ хэлбэрт дамжаар шилжих,

- Үйлдвэр, аж ахуйн байгууллагуудыг аж ахуйн тооцоонд шилжүүлэх, алдагдалтай газруудыг хаах,

- Үйлдвэрийн газруудад импортоор машин, тоног төхөөрөмж авэх валютын фонд байгуулах /хөрөнгийг үйлдвэр нь гаргана/.

- Дотоод үндэсний валютын бодит ханшийг зөв тогтоох, экспорт, импортын бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийг боловсронгуй болгох,

- Гадаад худалдааны үйл ажиллагаанд санхүүгийн үйлчилгээг сайжруулахад банкны үйл ажиллагааг нарийн тодорхой болгож, сахилгыг

хүчтэй болгох, олон улсын хамтын ажиллагаа, түүний өөрчлөлтөнд уян хатан хандах. гадаад худалдааны тэнцлийг сайжруулах,

– Олон улсын яармаг үзэсгэлэн, аукцион, биржийн үйл ажиллагаанд оролцох явдлыг идэвхжүүлэх,

– Олон улсын жуулчлалыг хөгжүүлэх,

– Мэргэжлийн дагуу боловсон хүчин бэлтгэх асуудлыг онцгой анхаарах нь чухал байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааг идэвхтэй, үр өгөөжтэй болгож чадна.

Эдийн засгийн гадаад харилцааны бас нэг чухал зүйл нь тус улсын нутаг дэвсгэрт гадаад орны дэмжлэг туслалцаатайгаар хамтын үйлдвэрлэл байгуулах явдал юм. Энэ нь хамтын ажиллагааг эрчимжүүлэх, үр бүтээлтэй болгох тус орны эдийн засгийн бүтцийг сайжруулах ач холбогдолтой.

Хамтын үйлдвэрлэлийн зорилго нь:

– Тус орны экспортыг хөгжүүлэх,

– Тус орны эдийн засагт гадаадын тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх,

– Үйлдвэр аж ахуйг удирдах, удирдлагын арга туршлагыг нэвтрүүлэх,

– Материал, санхүүгийн нэмэгдэл боломжийг ашиглах,

– Импортыг багасгах замаар дотоодын зах зээлийг чанартай бүтээгдэхүүнээр дүүрэн хангахад оршино. Хамтарсан үйлдвэрийг юуны өмнө хөнгөн, хүнс, уул уурхай, хими, машины үйлдвэрийн салбарт байгуулах нь чухал байна. Хөнгөн ба хүнсний үйлдвэрт эх орны бүтээгдэхүүнийг боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн гаргах, шинэ технологитой цөөн хүн ажиллах, хамтарсан үйлдвэр байгуулах нь ирээдүйтэй, өндөр ашигтай байх болно.

Машины үйлдвэрийн салбарын тухайд гэвэл Монгол улсын нөхцөлд эдийн засгийн үр ашигтай байх цогцолбор байна. Үүнд мал аж ахуй, тэжээлийн үйлдвэр, холбооны хэрэгсэл, хэмжих хэрэгсэл, цахим техникийн хэрэгслийн үйлдвэр орж болох юм.

Уул уурхайн салбарт дорнод бүсийн полиметаллын хүдрийн ордыг эзэмшиж тугалга, цайр хайлуулж, тун боловсруулалт хийх, мөн баруун бүсийн мөнгийг олборлон, боловсруулах үйлдвэр байгуулах, Таван толгойн коксжсон нүүрсний орд газрыг эзэмших нь Монгол улсын экспортын нөөцийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх ирээдүйтэй. Ховор металл, цахиур, бусад түүхийг боловсруулах, бичил цахим үйлдвэрлэх, бусад өндөр технологитой салбарын эх материал, үндсэн бүтээгдэхүүнийг бэлтгэх нь ашигтай байж болох юм.

Биотехнологи, электроникийг цаашид хөгжүүлэх нь Монгол улс Зүүн хойт Азийн орнуудтай хамтарсан үйлдвэр байгуулахад шинэ хэтийн төлөв нээж байна.

Эдүгээ манай улс АНУ-ын "Амикель" фирмтэй хамтран тэмээний ноосоор бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хамтарсан үйлдвэр байгуулах гэрээ, хэлэлцээр байгуулаад байна. Манай улс 80%, АНУ 20%-ийн хөрөнгө оруулалт хийж, жилдээ 750 тн тэмээний ноос, 70 тн сарлагийн хэвээр боловсруулах юм. I Мөн нефть хайгуулын ажилд америкийн шинэ технологи хэрэглэнэ. АНУ-д мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар хэлэлцээр байгуулав. Америкийн энхтайвны корпусын шугамаар ойрын үед Монгол Улсад англи хэлний 15 багш, тооцоолон бодох машины 2 мэргэжилтэн ирсэн. Эдгээр нь манай хоёр орны хооронд явуулах цаашдын өргөн хамтын ажиллагааны зөвхөн эхлэл юм.

Монгол улс Японы эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх боломжоо бий. 1990 онд жилдээ 100 мянган тн металл боловсруулах хүчин чадал бүхий төмөрлөгийн жижиг заводын суурийг тавилаа. Уг үйлдвэр Японы "Итоху", "Мицубиси" Ко-тай гэрээ байгуулсан, 45 сая долларын үнэтэй /зураг, тоног төхөөрөмж, угсралт, сургалтын үнэ/ бүгд 350 ажилчинтай байна. Зээлийг 1995

энд төлж дуусна. Үйлдвэр 1993-1995 онд ашиглалтанд орно. Ялон улсаас оношлох төвийн тоног төхөөрөмж худалдан авахаар тохиролцсоны дээр үндэсний телевизийн нэвтрүүлэг дамжуулахад зориулсан төхөөрөмж хэрэгсэл авна. Түүнээс гадна багс, ариун цэврийн цаас үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүд худалдан авна. Эмнэлгийн зориулалтаар нэг удаа хэрэглэх тариур, зүү үйлдвэрлэх жижиг үйлдвэр байгуулах тухай хэлэлцээрийг БНСУ-тай хийж байна. 2

Залуучуудын биеийн тамирын хувцас үйлдвэрлэх, лааны жижиг үйлдвэр байгуулах хэлэлцээрийг БНХАУ-тай хийлээ. Эмийн ургамал тарималжуулах, хиймэл мяндас үйлдвэрлэх, төмрийн хаягдал боловсруулж өргөч хэрэгцээний бараа үйлдвэрлэх салбарт хамтран ажиллах асуудлыг БНАСАУ-тай тохиролцож байна.

Манай улс энэ бүс нутгийн бэ дэлхийн бүх орон, ялангуяа өндөр хөгжилтэй орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх эрмэлзэлтэй байгаа болно.

Манай өдөөгийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу Зүүн хойт Азийн бүс нутагт хамтын ажиллагаа идэвхтэй хөгжүүлэх чигтэй байгаа. Үүнд: Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал зэрэг байгууллагатай ойртож хамтран ажиллах ба Төв Азийн бүс нутагт харилцан ойлгох, хамтран ажиллах уур амьсгал, итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах нь нэн чухал юм.

1. ГХЯ тоо баримт
2. Мөн тэнд